



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/61

Хажуу шинэ-Ус

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах бүх шатны бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажиллах шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаа баталсугай.

2.Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан гэнэтийн аадар бороо орох,түүний улмаас үерийн эрсдэл үүсэж болзошгүй байгаатай холбогдуулан үерийн гамшигтай тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг хангаж төлөвлөгөө гарган батлуулан ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Даваасүрэн)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

ДАРГА



ДАРГУУНАА

482401081

Засаг даргын 2021 оны 06
сарын 17-ний өдрийн 21/61
тоот захирамжийн хавсралт



СУМЫН ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Даваасүрэн (Засаг даргын орлогч)
Гишүүдэд: Б.Мөнхдэлгэр (1 дүгээр багийн Засаг дарга)
М.Амарзаяа (2 дугаар багийн Засаг дарга)
Н.Энхтайван (3 дугаар багийн Засаг дарга)
Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)
А.Бямбадорж (Мал эмнэлгийн улсын байцаагч)
Б.Мягмарсүрэн (Тархвар зүйч)
Н.Ганбат (Санхүү албаны дарга)
Н.Лхагва-Учрал (Газрын даамал)



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГЫН 2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН №49 ДҮГЭЭР
ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үүрэг	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч
1	Сумын Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагааг идэвхжүүлж гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан төлөвлөж, зохион байгуулалтын арга хэмжээ авах	06.18-09-15	Шуурхай штаб	Сумын онцгой комисс
2	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвөөс сум, багийн түвшинд цаг уурын төлөв байдал, хур тунадасны талаарх нарийвчилсан мэдээг тогтмол авч, иргэдэд тухай бүр хүргэх		Ус цаг уурын орчны шинжлэгээний төв	Сумын онцгой комисс, Шуурхай штаб
3	Нуурын арал, эрэг дагуу болон нуурын ам, бэл, гуу жалга, судгийн аманд айл өрх суурьшихгүй байхыг анхааруулах, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахыг хориглох, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхөд мэдэгдэл, албан шаардлага хүргүүлэх, нүүлгэн шилжүүлэх	06.18-09-15	Засаг даргын орлогч	Сумын онцгой комисс, Шуурхай штаб
4	Үерийн аюул, усны осол тохиолдож болзошгүй газруудад урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэг, усны гүнийг заасан тэмдэглэгээ байрлуулах, шинэчлэх, хүн олноор цугладаг газруудад хаалт, хашлага хийх, тор татах	06.18-09-15	Засаг даргын орлогч	Сумын онцгой комисс, Шуурхай штаб

5	Тээврийн хэрэгслийн жолооч, малчид анхаарал болгоомжтой зорчих, амралт, зугаалгын улирал эхэлж байгаатай холбогдуулан иргэдэд бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, архи согтууруулах ундаа хэрэглсэн үедээ нуурын усанд орохгүй байх анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээллийг цахимаар болон утсаар мэдээллэх	06.18-09-15	Засаг даргын орлогч, Багийн засаг дарга	Сумын онцгой комисс, Шуурхай штаб
6	Болзошгүй гамшиг, аюулт үзэгдлийн үед үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүн, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, техник хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах	06.18-09-15	Засаг даргын орлогч	Сумын онцгой комисс, Шуурхай штаб
7	Үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах арга хэмжээнд Засаг даргын нөөц хөрөнгө, гамшгийн эрсдэлийг бууруулах сан, орон нутгийн төсвөөс тодорхой хөрөнгө гаргах	06.18-09-15	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Сумын онцгой комисс, Шуурхай штаб